# БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 14 ХОНОГИЙН МЭДЭЭ 2022.01.31-02.14

СУМЫН ЗАСАГ ДАРГА Г.АНХБАЯР

# Удирдлага зохион байгуулалтын ажлын хүрээнд:

Буян үйлдэгч хэмээх Усан бар жилийн босгон дээр "Сумын аварга малчин өрх"-өөр:
1-р багийн малчин Л.Мөнхбат, эхнэр Д.Алтанцаг, 2-р багийн малчин Х.Үзмээ. Мөн "Мянгат малчин"-аар 2-р багийн малчин Б.Түвшинжаргал, Х.Үзмээ нар шалгарав.
Шагналыг "Буян үйлдэгч" хэмээх Усан бар жилийн босгонд Сумын ИТХ-ын дарга С.Басан, Сумын Засаг дарга Г.Анхбаяр, Орлогч дарга Э.Эрхэмбаатар нар гардуулсан.





# Удирдлага зохион байгуулалтын ажлын хүрээнд:

сумын Засаг даргын 2021 оны А/05 дугаар захирамжаар Цагаан сарын баярыг тэмдэглэн өнгөргүүлэх, гэнэтийн гамшиг, осол гарахаас урьдчилан сэргийлэхтэй холбогдлуулан 02 дугаар сарын 01-04-ний өдрийг дуустал байгууллагын дарга, эрхлэгч нарт хариуцлагатай жижүүр хийхийг үүрэг болгосон. Хариуцлагатай жижүүр хийх хугацаанд ямар нэгэн гарсан зөрчилгүй тайван байв.



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 31 өдөр　　Дугаар А/05　　Баянтал сум

Хариуцлагатай жижүүр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цагаан сарын баярыг тэмдэглэн өнгөрүүлэх, гэнэтийн гамшиг, осол гарахаас урьдчилан сэргийлэхтэй холбогдуулан 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 02 дугаар сарын 04-ний өдрийг дуустал хариуцлагатай жижүүр томилон ажиллуулахыг байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

2.Сумын хэмжээнд хариуцлагатай жижүүрт гарч, эргүүл шалгалт хийх хуваарийг нэгдүгээр хавсралтаар, хариуцлагатай жижүүрийн гүйцэтгэх үүргийг хоёрдугаар хавсралтаар тус тус батлалсугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэдээллээр хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (В.Гантуяа), Хэсгийн төлөөлөгч, ахмад (Х.Пүрэвжаргал) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ ДАРГА　　Э.ЭРХЭМБААТАР



Сумын Засаг даргын 2022 оны 01 сарын 31 өдрийн А/05 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРТ ГАРАХ БАЙГУУЛЛАГУУДЫН ХУВААРЬ

| № | Жижүүрт гарах байгууллага | Хариуцах албан тушаалтан | Хариуцах албан тушаалтны нэр | Утасны дугаар | Жижүүрт гарах огноо | Хугацаа |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ерөнхий боловсролын сургууль | Ерөнхий боловсролын сургуулийн захирал | Д.Цэрэнням | 99701303 | 2022.02.01 | 24 цаг |
| 2 | Эрүүл мэндийн төв | Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч | Б.Бямбасүрэн | 99276941 | | |
| 3 | Соёлын төв | Соёлын төвийн дарга | Х.Энхжаргал | 94044464 | 2022.02.02 | 24 цаг |
| 4 | Цэцэрлэг | Цэцэрлэгийн эрхлэгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч | Ч.Отгонцэцэг | 99806544 | | |
| 5 | "Талын илч" ОНӨҮГазар | "Талын илч" ОНӨҮГазрын дарга | А.Батжаргал | 99059086 | 2022.02.03 | 24 цаг |
| 6 | Хэсгийн төлөөлөгч | Хэсгийн төлөөлөгч/ цагдаагийн ахмад | Х.Пүрэвжаргал | 91118129 | | |
| 7 | Засаг даргын Тамгын газар | Засаг даргын Тамгын газрын дарга | В.Гантуяа | 94113190 | 2022.02.04 | 24 цаг |
| 8 | Цахилгаан түгээх сүлжээ | Сумын цахилгаанчин | Э.Хишигбаяр | 99557713 | | |







# Удирдлага зохион байгуулалтын ажлын хүрээнд:

Сар шинийн баярыг угтан Б.Зулбаяр, Б.Мөнхзул нар сумын 60-д өрхөд хандиваар 60 тонн нүүрс олгов.





# Удирдлага зохион байгуулалтын ажлын хүрээнд:

Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр бүх шатны сургууль, цэцэрлэгүүд танхимаар хичээллэхээр болсон. Дараах бэлтгэл ажлуудыг ханган ажиллаж байна. Үүнд:

1. 2022 оны 02 дугаар сарын 12-ны өдөр 14 цагт сургуулийн бүх ангийн эцэг эхийн хурлыг цахимаар зохион байгуулж сургалтын үйл ажиллагааны тухай мэдээлэл өгсөн. Хуралд нийт давхардсан тоогоор 1-9 ангийн 98 эцэг эх хамрагдсан.
2. бүх анги танхим, коридор, дотуур байрны өрөө тасалгаануудыг цэвэрлэн ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн.
3. 2022 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн дотуур байранд байрлах сурагчдыг түргэвчилсэн оношлуураар шинжилгээнд хамруулан хүлээн авч эхэлнэ.
4. Хичээл сургалтын үйл ажиллагааг 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн 1-р ангийг өглөөний 09:00 цаг, 2-9 дүгээр ангийг 08:00 цагаас хичээлнэ. Сурагчдыг сургуулийн хоёр хаалгаар оруулан хичээллэхээр бэлтгэл ажил 100% хангагдсан байна.







# Удирдлага зохион байгуулалтын ажлын хүрээнд:

- Сарын шинийн баярыг угтан 18 дугаар зөрлөгийн гэрэлтүүлгийн засаж янзласан.









# Удирдлага зохион байгуулалтын ажлын хүрээнд:

- 2-р сарын 4, 9-ний өдрүүдэд 2-р багийн Их ууланд 100 гаруй автомашин, 300 гаад хүн цугларсан хурдан морины уралдаан зохион байгуулж байсныг Засаг здаргын орлогч дарга, цагдаагийн бие бүрэлдэхүүний хамт таслан зогсоож холбогдохарга хэмжээг авсан.







# Удирдлага зохион байгуулалтын ажлын хүрээнд:

Сумын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс бүх албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд сар шинийн баярын өдрийг тохиолдуулан ойр орчимын 50м газрыг цэвэрлэх үүрэг өгч бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулав. Мөн цэргийн ангийн торны ар тал, 621-р хэсгийн хажуугийн хог хаягдлыг цэвэрлэсэн. Нийт 20 тонн гаруй хог хаягдлыг цэвэрлэж нэгдсэн хогын цэгт хаясан.









КОВИД-19



Хэвтэн эмчлүүлж байгаа– 11
ойрын хавьтал-30

01-р сарын 31-нээс 02-р сарын 12-ны байдлаар PCR – 71 иргэн, түргэвчилсэн - 17 иргэн



# АНХААРАЛ ХАНДУУЛСАН ТАНД БАЯРЛАЛАА